

## МОНГОЛ, ЭНЭТХЭГИЙН “ХӨРШ”-ИЙН ХАРИЛЦАА

*Э.Наран\**

Монгол Энэтхэгтэй шашин соёлын онцгой харилцаатай байсан түүхтэй. Хоёр улс 1955 онд дипломат харилцаа тогтоосон билээ. Монгол Улсын ардчилал шинэтгэлээс хойш Монгол Улс хөгжиж байгаа ардчилсан тогтолцоотой их гүрэн Энэтхэгтэй харилцах харилцаа есөн дээшлэх үед орлоо. Монгол, Энэтхэгийн буддын шашны өнө удаан соёлын харилцаан дээр үндэслэж, хоёр улс “оюун санааны хөрш”-ийн харилцаа тогтоов. Монголын тал Энэтхэг бол Монголын “чухал түнш бөгөөд гурав дахь хөрш” гэж үзэж байна. Энэ өгүүлэлд Монгол, Энэтхэгийн шашин соёлын харилцааг товч тайлбарлахын зэрэгцээ хоёр улсын цэргийн харилцаа, аюулгүй байдлын хамтын ажиллагаа болон Монгол, Энэтхэгийн харилцаан дахь Америкийн хүчин зүйл, түүний Хятадад үзүүлэх нөлөөг шинжлэн авч үзсэн.

### **Нэг. Шашны соёл бол хоёр талын харилцааны үндэс суурь**

Энэтхэг буддын шашны соёл үүссэн газар бөгөөд Хятадын “Тансан ламын баруун этгээдэд зорчсон тэмдэглэл” хэмээх сонгодог зохиолд дүрсэлсэн Тансан ламын зорчсон баруун газар бол одоогийн Энэтхэг гэдгийг бүгд мэднэ. Иймээс буддын шашныг бишрэн шүтдэг монголчуудын Энэтхэгтэй харилцах харилцаа өнө эртний уламжлалтай. Ялангуяа Монгол нийгмийн байгууллаа сольж, бие даасан нээлттэй гадаад бодлого хэрэгжүүлснээс хойш Энэтхэгтэй харилцаагаа бэхжүүлж, 4000 жилийн<sup>1</sup> уламжлалтай буддын шашны соёл дахин Монголд дэлгэрч, Монгол-Энэтхэгийн хамтын ажиллагааны харилцааг хөгжүүлж байна. 2001 оны 1 дүгээр сард Монгол Улсын хоёр дахь Ерөнхийлөгч Н.Багабанди Энэтхэгт айлчлах үеэр хоёр тал хэлэлцэн, Энэтхэгийн тал Монгол Улсыг тэдний ариун газар болох Бодьгаяад Монголын буддын сүм байгуулахыг зөвшөөрсний дараа 2004 оны 1 дүгээр сард Ерөнхий сайд Н.Энхбаяр Энэтхэгт айлчлах үеэр Энэтхэгийн тал “Эрдэнийн газар”-аа Монголын талд үнэ төлбөргүй шилжүүлж,<sup>2</sup> Монголын буддын шашны олон шавь нарт Энэтхэгийн буддын шашны ариун газар мөргөн бараалхах нөхцөл олгож, энэ нь Монгол, Энэтхэг хоёр талын шашны соёл болон бусад харилцааг хүчтэй хөгжүүлэв. 2006 оны 2 дугаар сард, Монгол Улсын гурав дахь ерөнхийлөгч Н.Энхбаяр Хятадын Төв телевизээр ярилцлага өгөхдөө “Бид Энэтхэгийг оюун санааны хөрш улс гэж үздэг, учир нь буддын шашны үзэл санаа Энэтхэгээс Монголд орж ирсэн”<sup>3</sup> гэжээ. Үнэндээ

\* Э.Наран - БНХАУ-ын Өвөр Монголын их сургуулийн Хөрш орон судлалын хүрээлэнгийн судлаач, доктор (Sc.D)

Монголд ерөнхий сайд, ерөнхийлөгч, УИХ-ын дарга гэсэн гурван том алба хашсан цорын ганц хүн Н.Энхбаяр нь чин сүсэгтэй буддын шашинтан билээ. Тэр МАХН-ын ерөнхий нарийн бичгийн дарга бөгөөд Монгол, Энэтхэгийн найрамдлын нийгэмлэгийн даргын алба хааж байхдаа Энэтхэгт айлчлах үеэрээ Далай ламын гадаадад нүүж гарсан засгийн газар байсан Дарамсалад очиж мөргөж байв. Далай ламыг Энэтхэгт байхад хүн амын 70%-аас дээш нь буддын шашин шүтдэг монголчууд Энэтхэгт очихоор улам их эрмэлзэх болсон аж. Түүнчлэн Далай ламын өргөмжилсөн Монголын IX Богд Жибзундамба Энэтхэгт амьдарч байсан болохоор Энэтхэгт очихыг эрмэлзэх монголчууд улам олширсон юм. Монголчууд хоёр улсын шашны байгууллагын хамтын ажиллагааны сувгаар жил бүр лам нараа Дарамсалад ном үзүүлэхээр томилон явуулдаг бөгөөд одоо ч Монголын олон залуу лам нар Энэтхэгийн Дарамсалад ном үзээд нутагтаа буцдаг. Монголд байгаа сүм хийдийн тэргүүн, хамба лам зэрэг дээгүүр зиндааны шашны мяндагтан нарын тодорхой хэсэг нь Энэтхэгийн Дарамсалад мэргэжил дээшлүүлж байсан хүмүүс байдаг юм.

1999 оны 7 дугаар сард IX Богд Жибзундамба Монголд очиж, YIII Богдыг нирваан болсноос хойш байгаагүй богд өргөмжлөх ажиллагаа болов. Арван жилийн дараа 2009 оны 10 дугаар сард IX Богд Жибзундамба дахин Монголд очиж нэг сар шахуу ном тавьжээ. Тэрээр энэ удаа Монголын хот хөдөөгөөр явж шашин дэлгэрүүлж, өргөн олон шавь нараа дагуулан мөргөл залбирал үйлдэж, дахин нэг шуугиулав. Тэрээр 2010 оны зун монголд ирж ном тавьж, Монгол Улсын харъяалалд орж, Монголын иргэн болсон. Ойрын жилүүдэд IX Богд Жибзундамбын ажил үйл амжилттай болж, богдын шавь монголчууд X Богдыг Монголоос тодруулахыг эрмэлзэж байгаа аж. Түүгээр барахгүй, Монгол Улсын олон нийт Монгол Улсын шашин ба төр бие даасан байх ёстой, дээр үеийнхтэй адил шашин төр хоёр нэгдмэл байж болохгүй, Монгол Улсад бэлэг тэмдгийн чанартай “сүүдрийн засгийн газар” байгуулж болохгүй гэж үзэж байна.

Энэтхэгийн талаас авч үзвэл, шашин түүхийн уг сурвалжийг ашиглан Монголд “шашны гадаад харилцааг” тогтоож, түүний дотор Түвдээс уламжилсан буддын шашныг Монголд дэлгэрүүлэхээр нэгэн ламыг элчин сайдаар томилсон байна. Лам Бакула Монголд олон жил элчин сайдын алба хашиж, жанчаа нөмөрсөөр тус улсад гадаад харилцааны олон чухал үйлсийг бүтээсэн билээ. Харин түүнийг жанч халсаны дараа Энэтхэгийн тал зориуд шарилыг нь Монголд оршуулж, нийслэл Улаанбаатарын буддын шашны төв Гандан хийдийн ойролцоо 2,25 метр өндөр мөнгөн суварга бүтээж, Энэтхэг-Монголын харилцааг хөгжүүлэх талаар оруулсан лам элчин сайдынхаа хувь нэмрийг үнэлэв.

Ингэж буддын шашны лам-элчин сайд хоёр улсын харилцааг хөгжүүлсэн “шашны гадаад харилцаа” нь дэлхийн дипломатын түүхэнд ховорхон юм.

Энэтхэгт олон хүн индуизм шүтэж байгаа ч гэсэн Энэтхэг Азийн дипломат харилцааг өргөтгөх, ялангуяа Зүүн хойд Азийн бүс нутгийн дипломат харилцааны үйл ажиллагааны орон зайг өргөтгөхөд буддын шашны нөлөө болон үүрэг роль чухал гэж үзсээр байгаа нь тус улсын эрх ашигт нийцэж байгаа аж. Иймээс Энэтхэгийн зарим эрдэмтэн уламжлалт буддын шашин соёлыг эрхэмлэн чухалчилж, соёлын аюулгүй байдлын стратегийг бэхжүүлэх санал дэвшүүлж байна. Энэ талаар Монгол Энэтхэгтэй адил үзэл бодолтой байна. 2001 оны 11 дүгээр сард Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаяр АНУ-д айлчлав. Тэрээр Сан Францискогийн Азийн санд лекц уншихдаа Монгол Улс буддын шашны соёлтой улс гэж мэдэгдсэн. Тэрээр, Монгол Улс буддын шашны соёлтой улс болохын хувьд христосын шашинтай улс (Орос) болон коммунист маягийн күнзын соёлтой (Хятад) улсын хооронд оршдог хөрш оронтой уусахгүй соёлын дархлаатай гэжээ.

### **Хоёр. Монгол, Энэтхэгийн харилцаа хөгжихөд цэргийн харилцаа гол тэнхлэг болж байна**

Шинэ зуунд орохын өмнөхөн шашин соёлын харилцаанаас гадна Монгол, Энэтхэг хоёр улсын бусад салбар дахь харилцаа тийм ч нягт байгаагүй. Энэтхэг өнгөрсөн зууны эцсээс авахуулаад “зүүнш харах” стратегийг хэрэгжүүлж, Энэтхэг Монголтой цэргийн хамтын ажиллагааны харилцаагаа өргөжүүлж байгаа нь түүний “зүүнш харах” стратегийн бодит алхмын нэг юм. Иймээс Энэтхэг Монголтой хамтын ажиллагаагаа ойрын жилүүдэд ихээхэн өргөтгөж байгаа нь цэргийн салбар болон аюулгүй байдлыг хамгаалах харилцаанд голлон илэрч байна. Монгол, Энэтхэгийн цэргийн харилцаа хоёр талын харилцааны гол тэнхлэг болж байна.

2001 оны 1 дүгээр сард Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди Энэтхэгт албан ёсны айлчлал хийж, хоёр тал “Монгол, Энэтхэгийн хамтарсан тунхаглал”, “Батлан хамгаалахын хамтын ажиллагааны хэлэлцээр” зэрэг долоон баримт бичигт<sup>4</sup> гарын үсэг зурсан бөгөөд “Батлан хамгаалахын хамтын ажиллагааны хэлэлцээр”-т цэргийн хамтарсан хээрийн сургууль хийх, хоёр улсын цэргийн дарга нарын харилцан айлчлал хийх зэрэг агуулгыг багтаасан байна. Хоёр тал чухал ач холбогдолтой “Батлан хамгаалахын хамтын ажиллагааны хэлэлцээр” байгуулсанаас хойш харилцан айлчлалаар цэргийн хамтын ажиллагааны олон төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлж эхлэв.

2004 оны 1 дүгээр сард Ерөнхий сайд Н.Энхбаяр Энэтхэгт албан ёсны айлчлал хийж, хоёр улсын хил хамгаалалтын хамтын ажиллагааны

харилцааг ахиулав. Хоёр улсын ерөнхий сайд нарын хэлэлцээний дараа гаргасан хамтарсан мэдэгдэлд хоёр тал “цаашид цэргийн харилцаа хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн бэхжүүлэх”-ээр санал нэгдсэн байна. Тэр үед хоёр улсын засгийн газрын байгуулсан нэг хэлэлцээрт Энэтхэг Монголтой хиймэл дагуул, агаарын пуужин тандах, газрын гадарга дээрх байгууламж, хиймэл дагуулын холбоо, газрын гадарга дээрх алсын удирдлага, цаг уур судлал, нислэгийн удирдлага болон эрдэм шинжилгээний солилцоо зэрэг өргөн салбарыг хамарсан хамтын ажиллагаа явуулах талаар тусгасан байна. Монголоос цэргийн дарга нарыг томилон Энэтхэгийн цэргийн дээд сургуульд дадлагажуулан бэлтгэх, түүний зэрэгцээ хамтарсан хээрийн сургууль хийх боломжийн талаар хоёр тал зөвлөн хэлэлцсэн. 2006 оны 5 дугаар сард Энэтхэгийн Батлан хамгаалахын сайд Парам Ражу Монголд айлчилж,<sup>5</sup> түүнийг Монгол Улс дээд хэмжээнд хүлээн авав. Энэхүү гурван хоногийн айлчлалын хугацаанд Монголын Батлан хамгаалахын сайд, Гадаад хэргийн сайдтай уулзаж ярилцан, хоёр тал хоёр улсын батлан хамгаалахын хамтын ажиллагааны харилцааг өргөжүүлэх талаар холбогдох сэдвээр зөвлөн ярилцаж, хамтын ажиллагааны олон хэлэлцээрт гарын үсэг зуржээ. Энэ удаа Монголын ерөнхийлөгч, ерөнхий сайд түүнийг тус тус хүлээн авч уулзжээ. Ерөнхийлөгч Н.Энхбаяр Парам Ражутай уулзахдаа хоёр улс Ази, Номхон далайн бүс нутгийн энх тайван тогтвортой байдлыг хамгаалах талаар “хамтын ажиллагааг явуулах өргөн боломж” байгаа талаар онцлон тэмдэглэсэн байна.

2003 оны 10 дугаар сард, Энэтхэг батлан хамгаалахын технологийн мэргэжилтний томоохон төлөөлөгчдийг Монголд илгээсний дотор цэргийн механикжсан болон явган цэрэг, артиллерийн цэрэг, агаарын цэргийн инженер оролцож, Монголын цэргийнхэнтэй хамжилцан тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ явуулах боломжийн талаар төлөвлөгөө боловсруулжээ. Тэр жилийн 11 дүгээр сард Энэтхэгийн Батлан хамгаалахын сайд Фернандес айлчилж ирсэн Монголын Батлан хамгаалахын сайдтай хэлэлцээ хийж, тохиролцоонд хүрч, Энэтхэгийн Батлан хамгаалахын сайд мэргэжилтнээ Монголын бүхий л зэвсэг төхөөрөмжид засвар үйлчилгээ хийхийг зөвшөөрсөн бөгөөд түүний дотор Орост үйлдвэрлэсэн “Миг-21” байлдааны онгоц орсон байв. Энэ нь Энэтхэгийн цэрэг анх удаа бусад улсын зэвсэг техникт ердийн засварыг хариуцсан явдал болов.

2004, 2005 онд Монгол, Энэтхэгийн тусгай төрлийн цэргийн анги харилцан бие биеийн нутагт цэргийн хамтарсан хээрийн сургууль хийсэн. 2004 оны 10 дугаар сард Монголын нутаг дэвсгэрт энхийг сахиулах хамтарсан цэргийн хээрийн сургууль хийсэн бөгөөд энэ нь Монгол, Энэтхэг хоёр улсын анхны хамтарсан хээрийн сургууль байв.

2005 оны 12 дугаар сард Монгол, Энэтхэг дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойг тохиолдуулан хоёр улсын цэрэг Энэтхэгийн умард хэсэгт Мизорамид үймээн дэгдээгчдийн эсрэг хамтарсан хээрийн сургууль хийсэн нь хоёр дахь хамтарсан хээрийн сургууль болов. Энэтхэгийн цэргийн талынхан “Монголын нутаг дэвсгэр Орос, Хятадтай хиллэдэг боловч терроризмд хилийн хориг хязгаар байхгүй тул Энэтхэгийн терроризмыг эсэргүүцэх арвин туршлага Монголд их тус болох болно” гэжээ. Тухайн үеийн Батлан хамгаалахын сайд Ц.Шаравдорж хээрийн сургуулийг үзэж шалгасан юм.<sup>6</sup> Монгол, Энэтхэгийн “Нүүдэлчин заан” гэж томъёолсон нэртэй гурав дахь хамтарсан цэргийн хээрийн сургууль 2007 оны 8 дугаар сарын эцэс 9 дүгээр сарын эхээр Улаанбаатараас 65 км зайтай Таван толгойн зэвсэгт хүчний сургалтын төвд болж, арав хоногийн хамтарсан сургууль хийсэн. Түүний зэрэгцээ Монголын талын урилгаар Энэтхэгийн цэрэг Монголын нутаг дэвсгэрт болсон “Хааны эрэлд - 2006, 2007, 2008, 2009, 2010”<sup>7</sup> зэрэг Монгол, Америкийн зэрэг олон улсын цэргийн хамтарсан хээрийн сургуульд оролцож байв.

2007 оны 8 дугаар сард Ерөнхийлөгч Н.Энхбаяр Монголд айлчилсан Энэтхэгийн аюулгүй байдлын хорооны төлөөлөгчдийг хүлээн авч уулзахдаа Энэтхэг бол Монгол Улсын “чухал түнш бөгөөд гурав дахь хөрш улс”, хоёр талын харилцаа “батлан хамгаалах, аюулгүй байдал болон стратегийн хамтын ажиллагааны чиглэлээр өргөжиж хөгжин байна” гэжээ.

Монгол Улс Энэтхэгийг дууриал авууштай, хөгжиж байгаа ардчилсан тогтолцоотой улс гэж үздэг. 2009 оны 9 дүгээр сард, Монгол Улсын анхны ардчилсан ерөнхийлөгч Ц.Элбэгдорж улс төрийн тавцанд гарсаны дараа анх Энэтхэгт айлчлав. Ц.Элбэгдорж хэлэхдээ, түүний Энэтхэгт ирсэн гол зорилго бол Монгол, Энэтхэгийн найрамдалт харилцааг урагшлуулан ахиулахын төлөө юм гэжээ. Тэрээр Энэтхэгийн Ерөнхий сайд Сингхтэй хэлэлцээр хийж, хоёр тал “Монгол, Энэтхэгийн хамтарсан тунхаглал” гаргаж, хоёр улс иргэний хэрэглээний цөмийн эрчим хүчний хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулжээ. Цөмийн эрчим хүчний хэлэлцээрээр Монгол Улс Энэтхэгт уран нийлүүлэх аж. Энэтхэгийн ерөнхий сайд Сингх Монголд 25 сая ам.долларын бага хүүтэй зээл олгож, эдийн засгийн тогтвортой тусламж үзүүлж, санхүүгийн хямралыг зохицуулна гэж мэдэгджээ.

### **Гурав. Монгол, Энэтхэгийн харилцаан дахь Америкийн хүчин зүйл болон түүний Хятадад үзүүлэх нөлөө**

Монгол, Энэтхэг хоёр Хятадын хойд өмнөд чухал хоёр хөрш болохынхоо хувьд Хятадтай урт газраар хиллэдэг. Монгол, Энэтхэгийн харилцааны хөгжил, ялангуяа хоёр талын цэргийн харилцааны хурдан хөгжил Хятадад нөлөөлөхгүй байж чадахгүй. Монголын талаас авч

үзвэл, Энэтхэгтэй харилцаагаа хөгжүүлж цэргийн харилцаа холбоо явуулахаар хөөцөлдөж, Энэтхэгийг “гол түнш, гурав дахь хөрш” гэж үзэж байгаа нь Хятад, Орос хоёр том хөршөөс сэрэмжлэх гэсэн зориудын санаа гэдэг нь тодорхой. 1994 онд Монгол Улсын Их хурлаас баталсан “Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал” гэсэн хууль эрх зүйн баримт бичигт Орос, Хятадтай харилцаагаа хөгжүүлэхийг “нэн тэргүүний чиглэл” болгосон ч гэсэн түүхийн шалтгаан болон геополитикийн бодлогын харилцаа зэрэг хүчин зүйлийн улмаас Монгол Улс Хятад, Орос хоёр том хөршдөө аль нэг хэмжээгээр эргэлзэн сэрэмжилж байдаг аж. Уг баримт бичигт “эдийн засгийн салбарт улсын стратегийн чанартай нөөц баялгийг аль нэг улс буюу хэд хэдэн улсын монопольд орох, Монгол Улсыг бусад улсын хараат орон болох болон түүхий эд нийлүүлэгч” болохоос сэрэмжилнэ гэж дурьдсан байна. Монгол Улс Хятад, Оросыг стратегийн болгоомжлолын объект гэж үзэж байгаагаар үүнийг тайлбарлана. Ойрын жилүүдэд Монгол Улс эдийн засгийн эрх ашгийг хөндсөн асуудал дээр газар зүйн орчин болон уламжлалт харилцааны хувьд, хоёр том хөрштэйгөө аль болохоор хамтран ажиллаж байгаа ч гэсэн улсын аюулгүй байдал дээр хоёр хөршид итгэх итгэл дутмаг байгаагаас Америк зэрэг ардчилсан улсыг түшиглэж байна. Энэ стратегийг хэрэгжүүлснээр “гурав дахь хөрш” гэсэн ухагдахуун бий болж, одоо Энэтхэг мөн Монголын гурав дахь хөрш болоод байна.

Энэтхэгийн талаас авч үзвэл, 21 дүгээр зуунд бүс нутгийн чанартай их гүрэн болох цаашилбал дэлхийн их гүрэн болох алс хэтийн их зорилго агуулж байна. Энэ стратегийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд геополитикийн бодлогод үндэслэн бодож үзэхэд Хятад, Оростой хил залгадаг стратегийн чухал ач холбогдолтой Монголтой харилцаагаа бэхжүүлэх болно. Энэ талаар хэвлэл мэдээллийн олон байгууллагын өгч байгаа мэдээлэл оргүй хоосон зүйл биш юм. 2006 оны 5 дугаар сард Энэтхэгийн цэргийн сүлжээний вэб сайтаар дамжуулсан “Indian today” сонины “Энэтхэг, Монгол дахь цэргийн баазаас Хятадтай эсэргүүцэлдэхээр төлөвлөв” гэсэн өгүүлэл нийтлэгдсэний дараа цэргийн мэдээллийн талаар Английн нэр хүндтэй долоо хоногийн “Jan’s defence weekly” гэсэн хэвлэлд 2007 оны 9 дүгээр сард “Энэтхэг, Монголтой батлан хамгаалах, аюулгүй байдлын хамтын ажиллагаагаа бэхжүүлж байгааг Хятад ажиглан харж байна” гэсэн гарчигтай өгүүлэл нийтэлсэн байна.

Угаасаа Хятад, Энэтхэг хоёр дэгжиж яваа “шинээр аж үйлдвэржиж буй их гүрэн” юм. Гэвч АНУ-ын Хятад болон Энэтхэгт хандах хандлага өөр өөр байна. АНУ Энэтхэгийг “ардчилсан улс” гэж үздэг, харин Хятадыг далд аюул заналтай улс гэж үздэг учраас ойрын

жилүүдэд Энэтхэгтэй цэрэг, улс төр, эдийн засгийн хамтын ажиллагаагаа ихээхэн хөгжүүлж, Энэтхэгээр Хятадыг стратегийн тулгуур болохыг нь хориглон саатуулахыг санаархаж байна.

Энэтхэг, Монголтой харилцаагаа идэвхтэй ойртуулж байгаа нь тус улсын онцлог газар зүйн байрлал, Америк-Монголын нягт харилцаа болон Хятадаас сэрэмжлэн болгоомжлох зорилтоос болсон нь тодорхой.

### **Зүүлт тайлбар**

1. Монгол Улсын Их Хурлын дарга Н.Энхбаярын 2005 оны 1 дүгээр сард Энэтхэгээс Монголд суугаа ЭСЯ, МУИС хамтран Улаанбаатар хотноо зохион байгуулсан “Энэтхэг, Монголын харилцаа эртний эх сурвалжтай” гэсэн олон улсын эрдэм шинжилгээний хурал дээр хэлсэн үг
2. М.Гантуяа: “Монгол, Энэтхэгийн харилцааны эртний эх сурвалж” Улаанбаатар, 2005, 29 дүгээр тал
3. “Улс төрч хүн аливаа үр дүнд сэтгэл ханах нь зохисгүй”, Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяртай хийсэн Хятадын Төв Телевизийн сурвалжлагчийн “Дээд хэмжээний айлчлал”-ын ярилцлага, 2006-02-22-ны өдөр
4. М.Гантуяа: “Монгол, Энэтхэгийн харилцааны эртний эх сурвалж” Улаанбаатар, 2005, 24 дүгээр тал
5. Фу Чэнь: “Өмнөд Азийн их гүрэн Энэтхэг Монголд цэргийн бааз байгуулахаар төлөвлөж байгаад дургүйцэж байна” “Хуаньчию шибао” сонин, 2006-5-12
6. Хао Лифэн: “Монгол Улс, Энэтхэгтэй олон улсын хамтын ажиллагаагаа өргөтгөнө”, Синьхуа, [www.sinhuanet.com](http://www.sinhuanet.com) 2009/03/20
7. (Монголын Үндэсний олон нийтийн телевиз) MNBT, оройн мэдээ, 2010 оны 8 сарын 8-ны өдөр

*Хятад хэлнээс орчуулсан: Л.Бэгзжав, Х.Цэгмид*